

**Үр дүн:** Нийт 241705 өвчтний түүхэнд судалгаа хийж, Кавасакийн өвчний 9 тохиолдлыг илрүүлсэн ба КӨ-тэй хүүхдүүдийн насыг авч үзэхэд 1 нас 4 сартайгаас 14 насны хооронд хэлбэлзэж, дийлэнх нь (77,8%) нь эрэгтэй хүүхдүүд байлаа. КӨ-ний 6 (67%) тохиолдолд үндсэн 6 шинжүүд бүгд илэрсэн ба бусад тохиолдлуудад 4 ба 5 шинжүүд илэрчээ. Халуурах, нүдний салст улайх, уруул амны хөндийд өөрчлөлт гарах шинжүүд нь хамгийн элбэг тохиолдож байсан бол хүзүүний тунгалгийн булчирхай томрох шинж нь харьцангуй цөөн илэрсэн байв. Зүрхний эхокардиографийн шинжилгээ хийлгэсэн 5 хүүхдэд бүгд зүрхний талаас хүндрэл гарч, зүрхний титэм судасны өргөсөл, цүлхэн үүссэн байна.

**Дүгнэлт:** КӨ-ний тохиолдлыг илрүүлэх үндэсний судалгаагаар КӨ-тэй хүүхэд Монгол Улсад байдаг болох нь тогтоогдоо. Иймд цаашид КӨ-ний үндэсний судалгааг үргэлжлүүлж, тохиолдлуудыг бүртгэж мэдээлдэг, шалтгааныг нь тогтоох шаардлагатай байна.

### **Нийслэлийн Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэгийг үнэлсэн судалгаа**

*Ж. Баярсайхан<sup>1</sup>, Ч. Бямбасүрэн<sup>2</sup>, Д.Өлзиймаа<sup>1</sup>*

<sup>1</sup>Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв,

<sup>2</sup>Улсын Клиникийн Төв Эмнэлэг

Өсвөр үеийнхний “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”-ийн талаарх мэдлэг хандлагыг тогтоох, гэр бүл төлөвлөлт болон, бэлгий харьцаа, жирэмслэлтээс сэргийлэх аргын мэдлэг тогтоох зорилгоор олон улсын болон Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн, өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэгдсэн төслийн үр дүнг төсөл хэрэгжсэн болон төсөл хэрэгжээгүй газрын хүүхдүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэг хандлагын түвшинг тогтоох замаар үнэлэв. Уг судалгааг системчилсэн түүврийн аргаар ХУД-ын ерөнхий боловсролын сургуулиудын НҮЭМ-н төсөлд хамрагдсан болон төсөлд хамрагдаагүй 15, 52, 7-р сургуулийн нийт 102 хүүхдээс системчилсэн түүврийн аргаар судалгааг авч, цуглуулсан мэдээ баримтаа Microsoft Excel, Microsoft Word программуудыг ашиглан боловсруулалт хийв.

Судалгааны ажлын таамаглал

**Н0:** НҮЭМ-ийн төсөл сургалтанд хамрагдсан эсэхээс үл хамаарч судалгаанд хамрагдсан ХУД-ийн арван нэгэн жилийн гурван сургуулийн 14-17 насны сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэгийн түвшин ижил байна.

**Н1:** НҮЭМ-н төсөл сургалтанд хамрагдсан сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэгийн түвшин сургалтанд хамрагдаагүй хүүхдүүдээс ялгаатай байна.

**Үрдүн:** НҮЭМ-тэй холбоотой мэдээлэл хангалтгүй гэж төсөлд хамрагдсан сурагчдын 38.1%, төсөлд хамрагдаагүй сурагчдын 26.6% нь тус тус үзэж, тэдний 11.5% нь илүү ихээр мэдээлэл шаардлагатай байна гэж хариулжээ. Төсөлд хамрагдсан сурагчдын 56.3% нь хамрагдаагүй сурагчдын 65.9% нь хэвлэлээс мэдээллээ олж авдаг гэсэн бол НҮЭМ-ийн талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилцаагүй гэж төсөлд хамрагдсан сурагчдын 53.7% нь төсөлд хамрагдаагүй сурагчдын 55.5% нь тус тус хариулсан нь төсөлд хамрагдсан сурагчдын 1.8% нь гэр бүлийнхэнтэйгээ бага ярилцдаг ажээ. БЗХӨ-ний талаар зохих хэмжээний ойлголттой гэж төсөлд хамрагдсан сурагчдын 87.5% нь, хамрагдаагүй сурагчдын 75% нь хариулсан нь төсөлд хамрагдсан сургагчдын мэдлэг хамрагдаагүй сурагчдаас 12.5%-иар илүү байгааг харуулж байна. БЗХӨ авсан байж болзошгүй гэж үзвэл хамгийн түрүүнд эмнэлэгт хандана гэж төсөлд хамрагдсан сургуулын сурагчдын 38.1% нь төсөлд хамрагдаагүй сургуулын сурагчдын 35.1% нь эмнэлэгт хандана гэж хариулсан нь төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургуулийн сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэг хандлага ялгаатай байгааг харуулж байна.

**Дүгнэлт:** Н1 таамаглал буюу НҮЭМ-н төсөл сургалтанд хамрагдсан сурагчдын НҮЭМ-ийн талаарх мэдлэгийн түвшин сургалтанд хамрагдаагүй хүүхдүүдээс ялгаатай байна.

### **HBsAg илэрсэн Монгол хүүхдүүдийн цочмог А вирусийн халдварын эмнэлзүйн онцлог**

*Ж.Улаан<sup>1</sup>, Я.Давгадорж<sup>2</sup>, Д. Чимэдноров<sup>1</sup>, Б.Батсүх<sup>1</sup>*

<sup>1</sup>Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв,

<sup>2</sup>Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль

Монгол улсад В вирус хепатит нь нутагшмал халдвар. Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 1991 оноос В вирус хепатитын вакцинаар шинээр төрсөн хүүхдүүдийг дархлаажуулж эхэлсний дүнд цочмог вирус хепатитын өвчлөл, элэгний дутагдлын улмаас нас барах нь эрс буурсан. Гэвч практикт цочмог А болон В вирус хепатитын хавсарсан хэлбэрийн өвчлөл бүрэн зогсоогүй байна.

**Зорилго:** HBsAg илэрсэн хүүхдүүдэд цочмог А вирусийн халдварын эмнэлзүйг судлах

**Үрдүн:** 1-р бүлгийн хүүхдүүдэд хүнд хэлбэр 7.8%, хүндэвтэр хэлбэр 23,5%, 2-р бүлэгт хүнд хэлбэр 50%,